

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/10

Арвайхээр

“Олон улсын сувилагчдын өдрийг тэмдэглэн”
өнгөрүүлэх тухай

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 04 сарын 05-ны өдрийн “Олон улсын сувилагчдын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” А/201 дүгээр тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Олон улсын сувилагч, эх баригчдын өдрийг “Сувилагч, эх баригчдын бие даасан байдал- Сувилахуй болон Эх барихуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулъя” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэхийг эрүүл мэндийн байгууллагын дарга захирал нарт үүрэг болгосугай.

2. Олон улсын сувилагч, эх баригчдын өдрийн үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, “Сувилагч-Эх баригчдын нэг өдөр” аяны хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Энэхүү арга хэмжээг аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх, мэргэжил арга зүйгээр хангаж, ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Ю.Ичинноров), Удирдлага төлөвлөлтийн хэлтэс (Н.Оюунтуяа)-т даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.ШИВААНҮРДЭВ

Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 04 дүгээр сарын 11-ны
өдрийн 440 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч: Ю.Ичинноров, ЭТХ-ийн дарга

Гишүүд: Б.Валя -Ерөнхий санхүүч

Н.Оюунтуяа- Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга

С.Дуламсүрэн -Нөхөн үржихүй өсвөр үе хариуцсан ахлах мэргэжилтэн

С.Энхцэцэг -Сувилахуй, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хариуцсан
мэргэжилтэн

Н.Төгс-Очир -Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн

П.Оюунбилэг -Нийгмийн асуудал, шагнал урамшуулал хариуцсан
мэргэжилтэн

Б.Баттуяа -Эх барихуйн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын даргын
2022 оны 04 дүгээр сарын 11-ны
өдрийн 11/11 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

“СУВИЛАГЧ-ЭХ БАРИГЧИЙН НЭГ ӨДӨР” АЯНЫ УДИРДАМЖ

Зорилго:

Сувилагч, эх баригчийн ёс зүй, мэргэжлийн үнэ цэнэ, бие даасан байдал, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд оршино.

Зорилт:

1. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд сувилагч, эх баригч мэргэжлийг сурталчлах, олон нийтийн мэдээллийн суваг, TV нэвтрүүлэг, ярилцлага, талархал, хүндэтгэл үзүүлэх гэх мэт төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах
2. Нийгэмд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, хавдраас урьдчилан сэргийлэх төрөл бүрийн арга хэмжээг ард иргэдэд чиглэсэн сургалт сурталчилгааг олон талт хэлбэрээр зохион байгуулах
3. Сувилахуйн болон эх барихуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлыг зохион байгуулах, шинэ технологи, сайн туршлагыг нэмэгдүүлэх
4. Сувилагч, эх баригчдын ажиллах орчин, нөхцөл, нийгмийн хамгааллыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх

Зохион байгуулагч: Өвөрхангай аймгийн Эрүүл мэндийн газар

Хугацаа: 2012 оны 04 дугаар сарын 11-наас 05 дүгээр сарын 04-ны хугацаанд зохион байгуулна.

Хамрах хүрээ: БОЭТ, Хархорин сумын Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн ЭМТ, хувийн хэвшлийн эмнэлэг хамрагдана.

Үр дүн: Сувилагч, эх баригч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн үнэ цэнэ нэмэгдэж, нотолгоонд суурилсан тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал сайжирч, олон нийт мэдээллээр хангагдсан байна.

Үнэлгээ, шалгаруулалт: Аяны үйл ажиллагааг удирдамжид заасан чиглэлийн дагуу шинэлэг хэлбэрээр зохион байгуулсан байдал, бодит үр дүн, тайлан бичилт зэргийг харгалзан үнэлнэ.

Зохион байгуулах үйл ажиллагааны чиглэл, хөтөлбөр:

№	Үйл ажиллагааны чиглэл	Хугацаа	Хариуцах байгууллага, албан тушаалтан	Хамтарч ажиллах байгууллага, албан тушаалтан	Шалгуур үзүүлэлт
<p>1. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд сувилагч, эх баригч мэргэжлийг сурталчлах, олон нийтийн мэдээллийн суваг, TV нэвтрүүлэг, ярилцлага, талархал, хүндэтгэл үзүүлэх гэх мэт төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулах</p>					
1.1	Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд сувилагч, эх баригч мэргэжлийг сурталчлах ажлыг бусад салбар байгууллагуудтай хамтран зохион байгуулах	2022 оны 4,5,9 сар	ЭМГ Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нар	ЭМГ, ХХҮГ, БСУГ Эрүүл мэндийн байгууллагууд	Сошиал хандалтын тоо Олон нийтэд хүрсэн байдлыг үйл ажиллагааны тайланд тусгах, баримтжуулах
1.2	"Сувилагч-Эх баригч дуулж байна дууны уралдаан зохион байгуулах	2022 оны 4,5 сар	ЭМГ-ын УТХ-ийн мэргэжилтэн Н.Төгс-Очир НЭМХ-ийн ахлах мэргэжилтэн С.Дуламсүрэн ЭТХ-ийн мэргэжилтэн С.Энхцэцэг	ЭМГ Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	Сошиал хандалтын тоо Олон нийтэд хүрсэн байдал, баримтжуулах
<p>2. Нийгэмд эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, хавдраас урьдчилан сэргийлэх төрөл бүрийн арга хэмжээг ард иргэдэд чиглэсэн сургалт сурталчилгааг олон талт хэлбэрээр зохион байгуулах</p>					
2.1	Сувилагч – Эх баригч, эмнэлгийн мэргэжилтнүүд олон нийтэд чиглэсэн эрүүл зан үйлийг төлөвшүүлэх сургалт, гарын авлага, видео контентуудыг бэлтгэн олон нийтийн мэдээллийн сувгаар цацах арга хэмжээг зохион байгуулах	2022 оны 4,5 сар	ЭМГ Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	ЭМГ Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд Төрийн болон төрийн бус байгууллагууд	Сошиал хандалтын тоо Хийсэн сургалт, хамрагдсан иргэдийн тоо Олон нийтэд хүрсэн байдлыг үйл ажиллагааны тайланд тусгах, баримтжуулах
<p>3. Сувилахуйн болон эх барихуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах зохион байгуулах, шинэ технологи, сайн туршлагыг нэмэгдүүлэх</p>					

3.1	“Сувилагч-Эх баригчдын бие даасан байдал-тусламж үйлчилгээний, чанар аюулгүй байдлыг сайжруулъя” уриан дор онол практикийн бага хурал зохион байгуулах	2022 оны 4,5 сар	ЭМГ-ын НЭМХ-ийн ахлах мэргэжилтэн С.Дуламсүрэн УТХ-ын мэргэжилтэн П.Оюунбилэг ЭТХ-ийн мэргэжилтэн С.Энхцэцэг ЭТХ-ийн мэргэжилтэн Б.Баттуяа	ЭМГ Чинмэнд эмнэлэг Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд	Үр дүн тайлан
3.2	Сувилагч, эх баригч нарыг орон нутгийн болон төрөлжсөн болон лавлагаа шатлалын эмнэлгүүдэд туршлага судлуулах ажлыг зохион байгуулах	2022 оны 4,5 сар	ЭМГ-ын НЭМХ-ийн ахлах мэргэжилтэн С.Дуламсүрэн ЭТХ-ийн мэргэжилтэн С.Энхцэцэг ЭТХ-ийн мэргэжилтэн Б.Баттуяа	ЭМГ Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд Төрийн болон төрийн бус байгууллагууд	Үр дүн тайлан
3.3	Сувилахуйн эх барихуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах нь бүсчилсэн арга хэмжээг зохион байгуулах	2022 оны 4,5 сар	ЭМГ Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нар	ЭМГ Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд Төрийн болон төрийн бус байгууллагууд	Үр дүн тайлан
4	Сувилагч, эх баригчдын ажиллах орчин, нөхцөл, нийгмийн хамгааллыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, дүгнэх	ЭМГ Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нар	2022 оны 4 сараас 2022 оны 10 сарын 30-ны өдөр хүртэл	Үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх	Үр дүн, тайлан